



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн
2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2025/01/НА-СТА-ТЕЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Ахлах аудитор Аудитор: Аудитор: Аудитор:</p> <p>Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn О.Нарангарав Цахим хаяг: narangarav.o@audit.gov.mn Т.Мөнхтогтох Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn Н.Мөнхнасан Цахим хаяг: munkhnasan.n@audit.gov.mn А.Дамчой Цахим хаяг: damchoia@audit.gov.mn</p>
---------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад орчин.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .	15
АУДИТЫН ТАЙЛАН	26
4.1 Ерөнхий зүйл	26
4.2 Материаллаг байдал.....	26
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	26
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	27
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	27
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	29
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	32

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АТБӨЯХ	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл
ЗАА	Захирагчийн ажлын алба
ЗГБХН	Зарим гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НААҮ	Нийтийн аж ахуйн үйлчилгээ
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨ	Орон нутгийн өмчит
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨХХК	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СБТ	Санхүүгийн байдлын тайлан
СҮДТ	Санхүүгийн үр дүнгийн тайлан
ТАХ	Төсөл арга хэмжээ
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ЭМГ	Эрүүл мэндийн газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2025.01.18 № 1-6/372

танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА О.БАТЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд аймгийн татварын болон татварын бус орлогыг 150,250.6 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэл 78.3 хувьтай буюу 117,715.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төсвийн орлого 32,535.1 сая төгрөгөөр дутуу биелсэн нь газрын дуудлага худалдааны орлого 25,789.4 сая төгрөгөөр тасарсантай холбоотой байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 35,051.3 сая төгрөгийн 294 алдаа, зөрчил илрүүлснээс 33,683.6 сая төгрөгийн 181 алдааг аудитын явцад залруулж, 41.6 сая төгрөгийн зөрчилд 15 төлбөрийн акт тогтоож, 621.6 сая төгрөгийн зөрчилд 55 албан шаардлага хүргүүлж, 704.5 сая төгрөгийн зөрчилд 37 зөвлөмж, хариуцлага тооцуулах 6 албан шаардлага хүргүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

442502052

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2023 оны 15/10 дугаар “Дуудлагаар худалдах аргаар хувьчлах тухай” тогтоолоор “Эм эргэлтийн сан” ОНӨҮГ-ийг татан буугдах шийдвэр гарсан боловч 2025 онд дуудлага худалдаа зарласан бөгөөд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажил удаашралтай хангалтгүй байна.

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	57,521,654.8	72,040,599.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	19,021,550.8	34,025,648.2
33	АВЛАГА	6,530,407.2	6,976,599.0
34	УРЬДЧИЛГАА	11,007,022.6	4,289,762.3
35	БАРАА МАТЕРИАЛ	7,089,748.7	9,618,322.3
36	НӨӨЦИЙН БАРАА	359,821.6	337,904.0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	13,513,104.0	16,792,364.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	130,948,636.9	195,865,967.8
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11,627,500.9	11,333,892.6
37300	Урт хугацаат зээл	11,627,500.9	11,333,892.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	119,321,135.9	184,532,075.2
39200	Биет хөрөнгө	112,039,002.0	177,091,460.1
39300	Биет бус хөрөнгө	7,282,133.9	7,440,615.1
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	188,470,291.7	267,906,567.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	63,167,382.0	79,080,557.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	33,535,466.7	29,168,690.7
41300	Өглөг	23,154,881.1	27,904,938.8
41400	Урьдчилж орсон орлого	10,380,585.6	1,263,751.9
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	29,631,915.3	49,911,866.6
42200	Урт хугацаат зээл	29,631,915.3	49,911,866.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	125,302,909.7	188,826,010.2
51	Засгийн газрын хувь оролцоо	125,302,909.7	188,826,010.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	19,297,398.0	19,297,398.0
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	23,148,187.9	23,166,487.9
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	523,470.7	523,470.7
51200	Хуримтлагдсан үр дүн	65,286,670.8	128,799,837.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	17,047,182.3	17,038,816.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	188,470,291.7	267,906,567.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	194,916,291.60	249,597,464.30
11	ТАТВАРЫН ОРЛОГО	89,586,635.60	108,739,825.40
110	Орлогын албан татвар	62,372,714.80	72,070,824.50
1100	Хувь хүний орлогын албан татвар	35,658,525.10	54,229,038.30
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-905,158.50	-1,226,576.30
1103	ААН-ын орлогын албан татвар	27,619,348.20	19,068,362.50
113	Хөрөнгийн албан татвар	3,838,773.70	8,195,282.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж	23,375,147.10	28,473,718.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	66,742,546.80	133,194,594.20
120	Нийтлэг татварын бус орлого	41,045,506.30	92,298,511.20
121	Хөрөнгийн орлого	25,650.00	43,875.00
122	Тусламжийн орлого	100,000.00	-
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	25,571,390.50	40,852,208.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	38,587,109.20	7,663,044.70
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	173,645,822.10	174,652,331.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	173,645,822.10	174,652,331.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	159,197,565.40	163,670,255.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,831,258.20	27,462,818.40

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,078,333.00	3,391,944.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,211,593.80	12,968,682.80
2104	Хангамж, бараа материалын зардал	98,133,103.10	57,551,277.30
2105	Норматив зардал	461,921.70	517,195.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	681,520.40	1,496,564.10
2107	Томилолт, зочны зардал	272,158.20	345,371.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,350,264.90	41,031,397.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,177,412.10	18,905,004.10
211	ХҮҮ	300,000.00	-
212	ТАТААС	294,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,854,256.70	10,982,076.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	21,270,469.50	74,945,133.10
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	2,387.20	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	23,984,443.40	11,693,743.90
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-2,711,586.70	63,251,389.20

2.3 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	125,467,086.30	125,467,086.30
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-167,125.60	-167,125.60
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	125,299,960.70	125,299,960.70
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-71,470.60	-71,470.60
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	2,313,537.70	2,313,537.70
7	Өмчид гарсан өөрчлөлт	472,468.60	472,468.60
9	Тайлант үеийн үр дүн	-2,711,586.70	-2,711,586.70
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	125,302,909.70	125,302,909.70
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	125,302,909.70	125,302,909.70
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-352,068.10	-352,068.10
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	124,950,841.60	124,950,841.60
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-60,507.10	-60,507.10
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	18,300.00	18,300.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	665,986.50	665,986.50
19	Тайлант үеийн үр дүн	63,251,389.20	63,251,389.20
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	188,826,010.20	188,826,010.20

2.4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	196,291,131.20	204,530,709.34
11	ТАТВАРЫН ОРЛОГО	89,586,635.60	108,735,796.13
110	Орлогын албан татвар	62,372,714.80	72,020,421.05
1100	Хувь хүний орлогын албан татвар	35,658,525.10	54,178,634.89
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-905,158.50	-1,226,576.31
1103	ААН-ын орлогын албан татвар	27,619,348.20	19,068,362.47
113	Хөрөнгийн албан татвар	3,838,773.70	8,241,656.49
118	Бусад татвар, төлбөр, хураамж	23,375,147.10	28,473,718.59
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	10,240,444.70	17,167,845.44
1181	Газрын төлбөр	11,413,373.70	8,426,114.78
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,721,328.70	2,879,758.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	67,084,248.70	86,740,889.86
120	Нийтлэг татварын бус орлого	41,487,208.20	45,844,806.86
121	Хөрөнгийн орлого	25,650.00	43,875.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	25,571,390.50	40,852,208.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	39,620,246.90	9,054,023.35
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	126,940,044.70	160,814,820.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	126,940,044.70	160,814,820.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	80,082,419.70	118,827,640.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,290,657.70	34,699,387.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,547,504.00	5,507,494.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,035,506.80	15,078,304.60
2104	Хангамж, бараа материалын зардал	11,216,156.60	9,666,623.60
2105	Норматив зардал	290,992.00	449,306.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	949,040.80	1,549,395.33
2107	Томилолт, зочны зардал	288,251.90	351,691.33
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,656,855.50	40,635,165.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,807,454.60	10,890,272.64
211	ХҮҮ	300,000.00	-
212	ТАТААС	294,000.00	200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,263,625.00	41,787,180.10
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	69,351,086.50	43,715,889.00
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	3,064,577.50	1,918,627.40
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	72,866,987.70	30,572,204.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	72,866,987.70	30,572,204.50
2200	Дотоод эх үүсвэрээр	72,866,987.70	30,572,204.50
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-69,802,410.30	-28,653,577.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-1,786,189.40	-58,214.53
14	Бусад эх үүсвэр	1,000,000.00	9,800.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2,636,200.50	-
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	149,988.90	68,014.50
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-2,237,513.20	15,004,097.45
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	21,259,063.90	19,021,550.80
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	19,021,550.80	34,025,648.20

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	196,196,539.40	153,358,530.44	42,838,008.96	78.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	142,596,288.10	115,420,269.97	27,176,018.13	80.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	79,015,772.10	68,224,868.71	10,790,903.38	86.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	26,894,305.80	25,950,852.25	943,453.55	96.49
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,444,938.40	3,208,664.57	236,273.83	93.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,097,198.20	12,944,121.16	1,153,077.04	91.82
2104	Хангамж, бараа материалын зардал	1,814,636.70	1,736,188.96	78,447.74	95.68
2105	Норматив зардал	350,583.40	349,500.29	1,083.11	99.69
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,164,948.20	2,092,675.11	72,273.09	96.66
2107	Томилолт, зочны зардал	388,767.30	310,041.32	78,725.98	79.75
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,586,921.90	21,012,953.87	7,573,968.03	73.51
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,273,472.20	619,871.18	653,601.02	48.68
211	ХҮҮ	577,712.10	-	577,712.10	-
212	ТАТААС	200,000.00	200,000.00	-	100
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	200,000.00	200,000.00	-	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,802,803.90	46,995,401.26	15,807,402.64	74.83
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	60,711,477.30	45,116,027.65	15,595,449.65	74.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,091,326.60	1,879,373.60	211,953.00	89.87
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	53,600,251.30	37,938,260.47	15,661,990.83	70.78
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	197,156,309.50	155,677,705.43	41,478,604.07	78.96
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	42,708,149.00	40,852,208.00	1,855,941.00	95.65
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	148,164,945.20	112,544,575.28	35,620,369.92	75.96
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,283,215.30	2,280,922.15	4,002,293.15	36.30
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	4,646,210.08	-4,646,210.08	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	6,965,385.06	-6,965,385.06	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,925.00	1,791.00	134.00	93.04
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	45.00	45.00	-	100
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	940.00	873.00	67.00	92.87

2.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	22,646,309.43	-22,646,309.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	22,231,612.27	-22,231,612.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	20,975,892.43	-20,975,892.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	1,544.46	-1,544.47
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	12,087.84	-12,087.84
2104	Хангамж, бараа материалын зардал	-	176,507.60	-176,507.61
2105	Норматив зардал	-	8,280.00	-8,280.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	73,212.98	-73,212.98
2107	Томилолт, зочны зардал	-	24,845.25	-24,845.25
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	17,979,558.27	-17,979,558.27
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,699,856.03	-2,699,856.03
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,255,719.84	-1,255,719.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	10,549.59	-10,549.60
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,245,170.25	-1,245,170.25
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	414,697.16	-414,697.16
2200	Дотоод эх үүсвэрээр	-	414,697.16	-414,697.16
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	22,646,309.43	-22,646,309.43
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	22,646,309.43	-22,646,309.43

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорноговь аймаг “Экологийн тэнцвэрт байдлыг хадгалсан, иргэн бүр нь тогтвортой хөгжлийн боловсролтой, эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай, амьжиргааны түвшин өндөр, үндэсний хэмжээнд өрсөлдөх чадвараар тэргүүлэгч аймаг болно” гэж эрхэм зорилгоо тодорхойлсон байна.

Дорноговь аймгийн хөгжлийн хэтийн зорилтыг хангахад дараах стратегийн зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Байгалийн нөөц баялгийг зөв зохистой ашиглаж, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн, орчны бохирдол, доройтлыг бууруулна.
- Хүн амын хөдөлмөр эрхлэлт, ногоон ажлын байрыг нэмэгдүүлэх замаар ажилгүйдэл, ядуурал, нийгмийн эмзэг байдлыг бууруулж, амьжиргааны түшинг дээшлүүлнэ.
- Иргэн бүрийн тогтвортой хөгжлийн боловсролыг дээшлүүлж, байгальд ээлтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ.
- Байгаль орчинд сөрөг нөлөөгүй экспортын чиг баримжаатай үйлдвэрлэл, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж, хариуцлагатай уул уурхай, тогтвортой хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, аялал жуулчлалыг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлнэ.
- Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- Хууль ёсыг эрхэмлэсэн, иргэдэд хүртээмжтэй, ил тод, хариуцлагатай, иргэдийн оролцоог бүх шатанд хангасан нэгдмэл бодлоготой сайн засаглалыг бэхжүүлнэ.

Дорноговь аймгийн Засаг даргын 2024 оны А/01 дүгээр захирамжаар “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хэрэгжилтийг хангах, аймгийн бичил, жижиг, дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуй нэгжийг тогтвортой хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор “2024 оныг Түншлэл-Хөгжил” зорилтот жил болгон зарласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь:

- Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах;
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах, аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төлөвлөгөө, хөтөлбөрийн төсөл боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- Аймгийн төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;
- Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх, аймгийн өмчийн эзэмшил, ашиглалтыг зохион байгуулж, аймгийн өмчийг бусдад эзэмшүүлэх, түрээслэх, худалдах, хувьчлах зэрэг асуудлаар захиран зарцуулах санал боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулан шийдвэрлүүлэх, энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасан асуудлаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн төслийг боловсруулж, холбогдох тооцоо, үндэслэл бүхий саналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж хэлэлцүүлэх;
- Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Аймгийн хэмжээний томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах арга хэмжээ авах чиг үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Тайлант онд Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь төсвийн 33 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийснээс, төлөвлөгөөт хяналт шалгалтыг 29 байгууллага, төлөвлөгөөт бусаар 4 байгууллагад хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна.

Шалгалтаар 534.3 сая төгрөгийн 424 зөрчил илэрч, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 201 акт тогтоон, 9 албан шаардлагыг хүргүүлсэн байна. Тайлант хугацаанд 417 зөрчлийг бүрэн арилгаж, 449.7 сая төгрөгийн төлбөрийг барагдуулж ажилласан ба биелэлт 84.6 хувьтай байна.

Монгол Улсын “Шилэн дансны тухай хууль”-д заасны дагуу 14 сумын 48 төсвийн байгууллага, аймгийн төвийн 10 байгууллага, нийт 58 байгууллагын 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн эсэхэд хяналт шалгалтыг хийж, нийт 8,888 мэдээллийг цахим хуудсанд тухай бүр байршуулж мэдээлэхээс 8,416 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 472 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/646 дугаар аймгийн Засаг даргын захирамжаар батлуулсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 79,436.3 сая төгрөгөөр буюу 42.1 хувиар *өссөн* байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	19,021.6	34,025.6	15,004.0
Авлага	6,530.4	6,976.6	446.2
Урьдчилгаа	11,007.0	4,289.8	-6,717.2
Бараа материал	7,089.8	9,618.3	2,528.5
Нөөцийн бараа	359.8	337.9	-21.9
Бусад эргэлтийн хөрөнгө	13,513.1	16,792.4	3,279.3
Урт хугацаат хөрөнгө оруулалт	11,627.5	11,333.9	-293.6
Үндсэн хөрөнгө	119,321.1	184,532.1	65,211.0

Нийт хөрөнгө	188,470.3	267,906.6	79,436.3
Өр төлбөр	63,167.4	79,080.6	15,913.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	125,302.9	188,826.0	63,523.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	188,470.3	267,906.6	79,436.3

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтүүдээс мөнгөн хөрөнгийн данс, авлагын данс, бараа материалын данс, бусад эргэлтийн хөрөнгийн данс, үндсэн хөрөнгийн данс, өр төлбөрийн данс, засгийн газрын хувь оролцоо дансууд нэмэгдэж, урьдчилгаа данс, нөөцийн барааны данс, урт хугацаат хөрөнгө оруулалт дансууд буурсан өөрчлөлт гарсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 34,025.6 сая төгрөг болж, өмнөх оноос 15,004.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	0.7	0.5	0.2
Банканд байгаа бэлэн мөнгө	19,020.9	34,025.1	15,004.2
Төгрөг	19,020.9	34,025.1	15,004.2
Төрийн сангийн харилцах	14,590.2	28,329.0	13,738.8
Арилжааны банк дахь харилцах	4,430.7	5,696.1	1,265.4
Дүн	19,021.6	34,025.6	15,004.2

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь: Нийт 20 байгууллагуудын ахмадын сангийн дансанд 159.4 сая төгрөг, НСС-ийн дансанд 834.5 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансны төвлөрүүлэлт 1,569.5 сая төгрөг, ХХС-ийн дансанд 2,315.9 сая төгрөг, аймгийн орон нутгийн ерөнхий орлогын дансанд 3,241.5 сая төгрөг, аймаг болон сумдын ОНХС-ийн дансанд 3,825.6 сая төгрөг, хөрөнгө оруулалтын барьцаа дансанд 16,382.6 сая төгрөг (Засгийн газрын 2024 оны 249 дүгээр тогтоол “Төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай”-ын дагуу)-ийн тус тус төрийн сангийн харилцах дансанд үлдэгдэлтэй байна.

Мөн кассад орон нутгийн өмчит 3 газрын 0.5 сая төгрөг, арилжааны банкинд нийт 12 газрын 5,696.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

Алтанширээ сумын ЗДТГ- Тус байгууллага нь тайлант хугацааны санхүүжилт болох 1.0 сая төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд тусгаагүй алдааг аудитаар залруулсан.

Хатанбулаг сумын ИТХ- Мөнгөн гүйлгээний тайланд мөнгөний үлдэгдлийг 1.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан алдааг аудитаар залруулсан.

Мандах сумын ИТХ- Ахмадын сангийн төвлөрүүлэлт 4.1 сая төгрөгийг СТ2А тайланд орлогоор, СТ1А тайланд 0.2 сая төгрөгийг мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлд буруу бүртгэсэн алдааг аудитаар залруулсан.

Алтанширээ сумын ХХС- Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг 11.6 сая төгрөгөөр дутуу тайлагнасан алдааг аудитаар залруулсан.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 6,976.6 сая төгрөг болж, өмнөх оноос 446.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	12.9	23.5	10.6
Төлбөртэй үйлчилгээний авлага	1.3	2.4	1.1
Зээлийн хүүгийн авлага	47.0	43.2	-3.8
Дансны авлага /ТӨҮГ/	1,298.7	1,615.8	317.1
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	1.2	5.0	3.8
Байгууллагаас авах авлага	1,185.5	1,427.9	242.4
Хувь хүмүүсээс авах авлага	91.0	1,666.6	1,575.6
Зээлийн авлага	3,892.8	2,192.2	-1,700.6
Дүн	6,530.4	6,976.6	446.2

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт 6,976.6 сая төгрөгийн авлагын 18.0 сая төгрөг нь сумын болон аймгийн ОНХС, 190.2 сая төгрөг нь өрхийн эрүүл мэндийн төвүүд, 1,423.1 сая төгрөг нь Чандмань-Илч ОНӨ ХХК, 2,378.2 сая төгрөг нь бусад байгууллага, 2,967.1 сая төгрөг нь сумдын ХХС-ийн авлагын үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

Улаанбадрах сумын ЗДТГ- Цалин хөлсний зардлаас ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 4.4 сая төгрөг шилжүүлсэн, 7 сарын НДШ тайланд 0.7 сая төгрөгийн цалин хөлс илүү тайлагнаж НДШ-д 0.2 сая төгрөгийг илүү төлж, тайланд авлагаар тусгаагүй алдааг аудитаар залруулсан.

Замын-Үүд сумын ХХС- СБТ-д зээлийн авлагын үлдэгдлийг 4.7 сая төгрөг, өглөгийн үлдэгдлийг 0.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан алдааг аудитаар залруулсан.

Аймгийн ОНХС- Тайлант онд ИТХ-аар батлагдсан "Сайншанд сумын 2 дугаар багийн Дэнж гудамж 11, 12 дугаар хэсэгт авто зам шинээр хийж төв замтай холбох ажил" ТАХ-ний гэрээнд 6.5 сая төгрөгийн норм, нормчлолын сангийн зардлыг ТАХ-ний өртөгт шингээн илүү шилжүүлснийг авлагад тусгаагүй алдааг аудитаар залруулсан.

Сайхандулаан сумын ХХС- Тайлант оны зээлийн авлагын эхний үлдэгдлийг 14.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан алдааг аудитаар залруулсан.

Сайхандулаан сумын ЗДТГ- СБТ-д НДШ-ийн 0.2 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийн авлага 70.6 сая төгрөг, нийт 70.8 сая төгрөгийн авлагыг тайлагнаагүй алдааг аудитаар залруулсан.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 4,289.7 сая төгрөг болж, өмнөх оноос 6,717.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	599.6	2,016.6	1,417.0
Урьдчилгаа тооцоо	10,407.4	2,273.1	-8,134.3
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	10,400.5	2,265.9	-8,134.6
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	6.9	6.9	-
Цалингийн урьдчилгаа	-	0.3	0.3
Дүн	11,007.0	4,289.7	-6,717.3

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал бэлтгэх урьдчилгаа дансны үлдэгдэл 2,265.9 сая төгрөг нь "Чандмань Илч" ОНӨ ХХК-ийн "Мандах наран-5", "Саран хөхөө" театрын тендерийн ажилтай холбоотойгоор материалын захиалга, уурын зуухны тоног төхөөрөмж, барилгын материал худалдан авахтай холбоотой бараа материал бэлтгэсэн, урьдчилж гарсан зардлын дансны үлдэгдэлд байгаа 1,136.6 сая төгрөг нь Замын-Үүд сумын ОНХО-аар Мандах наран хорооллын гадна

зам талбайн ажил, гадна цахилгаан, Гаалийн гражийн урд тал хавтан зам тавих ажил, Борхойн 14-17 дугаар гудамжруу Дулааны шугам татахад шилжүүлсэн урьдчилгаа, 15.6 сая төгрөг нь “Үүлэн зардас” ХХК-аар аймгийн түүхэн кино бүтээлгэхээр 2019 онд урьдчилж шилжүүлсэн зардал, 200.0 сая төгрөг нь Мандах сумын ОНХС-ийн хөрөнгөөр Өехий багт Юнителийн сүлжээний өргөтгөл барьсан урьдчилгаа, бусад 671.6 сая төгрөг нь 5 сумдын урьдчилгаа тооцооны үлдэгдэл байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 9,618.3 сая төгрөг болж, өмнөх оноос 2,528.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	1,089.5	1,138.9	49.4
Тусгай зориулалттай материал	563.0	675.3	112.3
Эм боох материал	526.5	463.6	-62.9
Дуусаагүй үйлдвэрлэл	-	356.7	356.7
Бэлэн бүтээгдэхүүн	89.7	187.4	97.7
Хангамжийн материал	5,736.4	7,789.2	2,052.8
Бичиг хэргийн материал	143.2	177.3	34.1
Аж ахуйн материал	3,321.4	4,791.0	1,469.6
Сэлбэг хэрэгсэл	212.2	228.9	16.7
Түлш, шатах тослох материал	131.2	155.8	24.6
Барилгын засварын материал	2.0	2.0	-
Хүнсний материал	2.2	0.1	-2.1
Бусад хангамжийн материал	1,924.2	2,434.1	509.9
Мал амьтад	174.1	146.1	-28.0
Дүн	7,089.7	9,618.3	2,528.6

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны нийт 9,618.3 сая төгрөгийн үлдэгдлийн 167.9 сая төгрөг нь Байгал орчны газар, 274.4 сая төгрөг нь аймгийн Засаг даргын Тамгын газар, 309.8 сая төгрөг нь Мандах сум, 348.4 сая төгрөг нь Дэлгэрэх сум, 413.0 сая төгрөг нь Өргөн сум, 452.4 сая төгрөг нь Айраг сум, 848.5 сая төгрөг нь Замын-Үүд сум, 1,345.6 сая төгрөг нь Орон нутгийн өмчийн газар, 1,618.0 сая төгрөг нь бусад сумд, 1,796.7 сая төгрөг нь Сайншанд сум, 2,043.6 сая төгрөг нь Чандмань Илч ОНӨ ХХК-ий бараа материалын үлдэгдлүүд байна.

Аудитын илрүүлэлт:

Агатова ЗГБХН- Тайлант хугацаанд нийт 11.0 сая төгрөгийн бараа материал акталж, данснаас хассан ба түүний 9.5 сая төгрөгийг эм, эмнэлгийн хэрэгслийг шийдвэрлэж ажиллаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Мишээлт мана ӨЭМТ- Бараа материалын данснаас нийт 23.5 сая төгрөгийн хөрөнгө акталснаас 18.4 сая төгрөгийг хугацаа дууссан эмийг шийдвэрлээгүй тул албан шаардлага хүргүүлсэн.

Талс зам ӨЭМТ- Тайлант хугацаанд ЭМГ-аас үнэ төлбөргүй 36.9 сая төгрөгийн вакцин, эм, хэрэгслийг хуваарилсан байна. Бараа материалын данснаас нийт 4,474.8 сая төгрөгийн хугацаа дууссан эмийг акталж, данснаас хасаж бүртгэсэн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Замын-Үүд сумын ЗДТГ- Байгууллагын эм боох материалын дансанд 23 нэр төрлийн 96,158 ширхэг 370.1 сая төгрөгийн ковидын үеийн эм, эмнэлгийн хамгаалах хэрэгслийг шийдвэрлэж ажиллаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Борхойн наран ЗГБХН- Тайлант хугацаанд 15.3 сая төгрөгийн бараа материалын зарлагыг алдаатай бүртгэсэн алдааг аудитаар залруулсан.

Замын-Үүд сумын ЗДТГ- Малын нас дэвшилтийг зөрүүтэй бүртгэж, СҮДТ-д 14.9 сая төгрөгөөр илүү тайлагнасан алдааг аудитаар залруулсан.

Аймгийн ИТХ- Завсрын аудитаар тайлант хугацааны 8.2 сая төгрөгийн шатахуун, 19.1 сая төгрөгийн талоныг няравын тайлангаар зарцуулж тайлагнасан боловч санхүүгийн программд зардлыг орхигдуулснаас үлдээгдлээр тайлагнасан алдааг аудитаар залруулсан.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 16,792.3 сая төгрөг болж, өмнөх оноос 309.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	2,969.4	-	-2,969.4
БЗЭБуй эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ	13,513.1	16,792.3	3,279.2
Дүн	16,482.5	16,792.3	309.8

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

БЗЭБуй эргэлтийн хөрөнгийн дансны үлдэгдэл 16,792.3 сая төгрөг нь “Түрээсийн орон сууц” хөтөлбөрөөр иргэдэд түрээслүүлсэн орон сууцыг бүртгэж авсантай холбоотой байна.

3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 184,532.1 сая төгрөг болж, өмнөх оноос 65,211.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	112,038.9	177,091.5	65,052.6
Барилга, байгууламж, орон сууц	55,913.5	77,503.0	21,589.5
Авто-тээврийн хэрэгсэл	6,753.9	8,111.4	1,357.5
Машин тоног төхөөрөмж (компьютер)	8,909.0	16,313.7	7,404.7
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,366.4	2,224.0	857.5
Зам, гүүрний байгууламж	9,337.9	9,594.9	257.0
Түүх соёл, музейн дурсалт зүйлс	48.7	48.7	-
Бусад үндсэн хөрөнгө	17,524.7	29,316.6	11,791.9
Дуусаагүй барилга, байгууламж	12,134.1	33,928.7	21,794.6
Ном	50.7	50.5	-0.2
Биет бус хөрөнгө	7,282.1	7,440.6	158.5
Программ хангамж	86.2	79.8	-6.4
Бусад биет бус хөрөнгө	7,195.9	7,360.8	164.9
Дүн	119,321.0	184,532.1	65,211.1

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт 65,211.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: Бүтцийн өөрчлөлтөөр шилжиж ирсэн хөрөнгө 50.0 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 1,326.7 сая төгрөг, худалдан авсан 2,221.0 сая төгрөг, хандиваар 2,449.1 сая төгрөг, балансаас баланст шилжүүлсэн авсан 22,450.5 сая төгрөгөөр, бусад 60,287.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Тус онд дахин үнэлгээний хорогдол 97.2 сая төгрөг, хөрөнгө худалдан борлуулсан 139.5 сая төгрөг, шилжүүлсэн 541.3 сая төгрөг, хөрөнгө акталсан 1,458.6 сая төгрөг, бусад 12,182.4 сая төгрөгөөр тус тус хасагдсантай холбоотой байна.

Дуусаагүй барилга байгууламжийн дансны үлдэгдэлд байгаа 33,928.7 сая төгрөгөөс 21,884.3 сая төгрөгийн аймаг болон сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ажил, 12,044.4 сая төгрөгийн улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ажил бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Аймгийн ИТХ- Тайлант хугацаанд үндсэн хөрөнгийн шинж чанартай 126.1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг эргэлтийн хөрөнгөд бүртгэсэн ба үүнээс 4.0 сая төгрөгийн эд хөрөнгийг өөрийн үйл ажиллагаанд ашиглахаар болсныг үндсэн хөрөнгийн дансанд бүртгээгүй, бусдад шилжүүлсэн 122.0 сая төгрөгийн хөрөнгийг аж ахуйн материалын дансанд бүртгэсэн зөрчилд зөвлөмж өгсөн.

Айраг сумын ЗДТГ- Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүйд 10 ширхэг 41.7 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдэл өртөг хасах утгатай (-2.8 сая төгрөг) тайлагнасан алдааг аудитаар залруулсан.

Өргөн сумын ЗДТГ- Тус сумын ЗДТГ-аас балансаас балансад шилжиж ирсэн 50.0 сая төгрөгийн өртөгтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн Prado-150 маркийн автомашиныг өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлтээр үнэлгээг шинэчлэн тогтоож 20.0 төгрөгийн үлдэх өртөгтэйгээр тайлагнасан алдааг аудитаар залруулсан.

Хатанбулаг сумын ЗДТГ- Тайлант хугацааны элэгдлийн зардлыг 87.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан алдааг аудитаар залруулсан.

Улаанбадрах сумын ЗДТГ- Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг 188.3 сая төгрөгөөр, тайлант оны элэгдлийн зардлыг 168.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан алдааг аудитаар залруулсан.

Хатанбулаг сумын ЗДТГ- Ашиглалтад хүлээн авсан орон сууцны барилгын өртгийг 417.7 сая төгрөгөөр, хөрөнгийн сайжруулалтыг 760.6 сая төгрөгөөр дутуу тусгасан алдааг аудитаар залруулсан.

Борхойн наран ЗГБХН- Тайлант хугацаанд аймгийн ОНХО-аар гүйцэтгэж, ашиглалтад орсон 950.1 сая төгрөгийн барилгыг бүртгэл тайланд тусгаагүй алдааг аудитаар залруулсан.

3.4.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 79,080.6 сая төгрөг болж, өмнөх оноос 15,913.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөр	177.8	229.2	51.4
Ажилчидтай холбогдсон өглөг	24.7	111.4	86.7
Бараа үйлчилгээний зардлын өглөг	33.1	13.8	-19.3
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	120.0	104.0	-16.0
Бусад өглөг	22,977.0	27,675.7	4,698.7
Байгууллагад төлөх өглөг	3,730.9	1,537.3	-2,193.6
Хувь хүмүүст төлөх өглөг	18.5	18.7	0.2
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	9.2	-	-9.2
Татварын өглөг /ТӨҮГ/	279.1	1,452.7	1,173.6
Дансны өглөг /ТӨҮГ/	18,939.3	24,666.9	5,727.6
Урьдчилж орсон орлого	10,380.6	1,263.8	-9,116.8
Урт хугацаат өр төлбөр	29,631.9	49,911.9	20,280.0
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	11,627.5	11,333.9	-293.6
Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	18,004.4	38,578.0	20,573.6
Дүн	63,167.3	79,080.6	15,913.3

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн өглөг данс 229.2 сая болж 51.4 сая төгрөгөөр өссөн нь ажилчидтай холбогдсон өглөг өссөнөөс шалтгаалсан байна.

Бусад өглөг данс нь 27,675.7 сая төгрөг болж 4,698.7 сая төгрөгөөр өссөн нь аймгийн орон нутгийн орлого тасарсантай холбогдуулан аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээний санхүүжилтийн өглөг нэмэгдсэнтэй холбоотой байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Дагшин- Эрдэнэ ОНӨХХК-ийн 13.9 сая төгрөгийн өр, аймгийн ерөнхий орлогын Азийн хөгжлийн банкны төслийн зээл 11,333.9 сая төгрөгийн урт хугацаат зээл, Чандмань-Илч ОНӨХХК-д шилжүүлсэн орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөвт ажил 38,564.1 сая төгрөгийн өр төлбөрүүд тус тус бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Сайхандулаан сумын ЗДТГ- Санхүүгийн тайланд тусгагдсан 2.1 сая төгрөгийн хувь хүмүүст төлөх өглөгийг тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Аймгийн ИТХ- Ээлжийн амралтын тооцоог бүртгэхдээ цалингийн тооцоолсон дүнтэй давхардуулан бүртгэж 2.1 сая төгрөгийн өглөг илүү тусгасан алдааг аудитаар залруулсан.

Хөвсгөл сумын ЗДТГ- Тус байгууллага нь тайлант хугацаанд ОНХС-аас ажилчдын орон сууцны дулаан, цэвэр бохир усны шугамын ажилд 4.4 сая төгрөгийг зарцуулсан ба тус өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй алдааг аудитаар залруулсан.

3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 186,948.0 сая төгрөг болж, өмнөх оноос 61,645.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	19,297.4	19,297.4	-
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	23,148.2	23,166.5	18.3
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	523.5	523.4	-0.1
Хуримтлагдсан үр дүн	65,286.7	126,921.9	61,635.2
Өмнөх үеийн үр дүн	68,042.5	65,548.5	-2,494.0
Тайлант үеийн үр дүн	-2,755.8	61,373.4	64,129.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	17,047.2	17,038.8	-8.4
Дүн	125,303.0	186,948.0	61,645.0

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт:

Мандах сумын ХХС- СБТ-д өмнөх үеийн үр дүнг 1.5 сая төгрөгөөр илүү тайлагнасан алдааг аудитаар залруулсан.

Эрдэнэ сумын ХХС- Тайлант онд үүссэн хүү алдангийн тооцооллыг алдаа хийж тайлант үеийн үр дүнг 3.5 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн алдааг аудитаар залруулсан.

Хөвсгөл сумын ХХС- СБТ-д тайлант оны үр дүнг 15.6 сая төгрөгөөр илүү тайлагнасан алдааг аудитаар залруулсан.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Аудитын илрүүлэлт:

Хатанбулаг сумын Засаг дарга- Тайлант онд тус сумын төсвийн орлого 6,177.5 сая төгрөгийн төлөвлөгөөнөөс 4,845.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 78 хувьтай биелсэн байна. Орлогыг үндэслэлгүй төлөвлөснөөс нийт 1,332.0 сая төгрөгөөр орлого тасарсанд цаашид төсвийн орлогыг бодит тоон мэдээлэлд үндэслэн төлөвлөх, батлагдсан орлогын төлөвлөгөөг биелүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгсөн.

3.5.1 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Хүснэгт 10. Төсвийн орлого

Орлогын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөгөөр/	
			Зөрүү	Хувь
I.НИЙТ ОРЛОГЫН ДҮН	147,524.9	115,934.7	31,590.2	78.6
II.УРСГАЛ ОРЛОГО	147,494.9	115,890.8	31,604.1	78.6
III.ТАТВАРЫН ОРЛОГО	142,648.0	108,735.7	33,912.3	76.2
1.Орлогын албан татвар	78,624.9	72,020.4	6,604.5	91.6
1.1.Хувь хүний орлогын албан татвар	48,924.9	54,178.6	-5,253.7	110.7
1.1.1. Цалин хөлс, түүнтэй адилтгах бусад орлого	41,086.2	44,507.5	-3,421.3	108.3
1.1.2. Үйл ажиллагааны орлогын татвар	1,926.0	2,213.0	-287.0	114.9
1.1.3. Хадгаламжийн хүүгийн орлого	1,802.6	2,021.2	-218.6	112.1
1.1.4. Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар	2,951.6	3,737.0	-785.4	126.6
1.1.5. Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	1,158.5	1,699.9	-541.4	146.7
1.1.7. Хувь хүний орлогын албан татварын буцаалт	-1,300.0	-1,226.6	-73.4	94.4
1.2.ААН-ийн орлогын албан татвар	31,000.0	19,068.4	11,931.6	61.5
1.2.1. ААН-ийн орлогын албан татвар	31,000.0	19,068.4	11,931.6	61.5
2.ӨМЧИЙН АЛБАН ТАТВАР	6,246.7	8,241.6	-1,994.9	131.9
2.1. Үл хөдлөх хөрөнгийн татвар	4,310.0	6,484.3	-2,174.3	150.4
2.2. Галт зэвсгийн албан татвар	30.6	31.7	-1.1	103.6
2.3. АТБӨЯХ-ийн албан татвар	1,500.0	1,456.5	43.5	97.1
2.4. Малын тоо толгойн албан татвар	406.1	269.1	137.0	66.3
4. БУСАД ТАТВАР	57,776.4	28,473.7	29,302.7	49.3
4.1. Улсын тэмдэгтийн хураамж	18,234.7	16,203.0	2,031.7	88.9
4.2. Ан агнах зөвшөөрлийн хураамж	708.1	701.3	6.8	99.0
4.3. Газрын төлбөр	6,921.6	4,215.5	2,706.1	60.9
4.4. Дуудлага худалдааны орлого	30,000.0	4,210.6	25,789.4	14.0
4.5. Рашаан, ус ашигласны төлбөр	880.1	2,178.5	-1,298.4	247.5
4.6. Хог хаягдлын хураамж	557.0	560.2	-3.2	100.6
4.8. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	474.9	404.6	70.3	85.2
IV.ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,846.9	7,155.0	-2,308.1	147.6
1. Түрээсийн орлого	30.0	128.2	-98.2	427.3
2. Хүүгийн орлого	577.7	-	577.7	-
3. Торгуулийн орлого	1,869.5	2,602.9	-733.4	139.2
4. Нэр зааж ангилагдаагүй орлого	2,050.0	3,819.9	-1,769.9	186.3
5. Газрын тосны орлого	-	104.0	-104.0	104.0
6. Төсөвт байгууллагын өөрийн орлого	319.7	500.1	-180.4	156.4
V.ХӨРӨНГИЙН ОРЛОГО	30.0	43.9	-13.9	146.3
1. Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	30.0	43.9	-13.9	146.3

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд татварын болон татварын бус орлогыг 147,524.9 сая төгрөгөөр төлөвлөснөөс 115,934.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж 31,590.2 сая төгрөгөөр дутуу буюу гүйцэтгэл 78.6 хувьтай байна. Биелээгүй орлогын шалтгааныг авч үзвэл:

- Аж ахуй нэгжийн орлогын албан татварын орлогын төлөвлөгөө 31,000.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 19,068.4 сая төгрөгийг төвлөрүүлж, 61.5 хувийн гүйцэтгэлтэй 11,931.6 сая төгрөгөөр тасарсан нь улсын төсөвт төвлөрүүлэх уул уурхайн компанийн орлого дутуу төвлөрсөнтэй холбоотой байна.

- Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө 406.1 сая төгрөг төвлөрүүлэхээс 269.1 сая төгрөг төвлөрүүлж, 66.3 хувийн гүйцэтгэлтэй 137.0 сая төгрөгөөр тасарсан нь байгаль цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалж малын тоо толгой хоргодож, зарим малчид татвараа дутуу төлсөнтэй холбоотой байна.
- Улсын тэмдэгтийн хураамжийн орлогын төлөвлөгөө 18,234.7 сая төгрөг төвлөрүүлэхээс 16,203.0 сая төгрөг төвлөрүүлж, 88.9 хувийн гүйцэтгэлтэй 2,031.7 сая төгрөгөөр тасарсан нь Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газраас төвлөрүүлэх улсын тэмдэгтийн хураамжийн орлого тасалдсантай холбоотой байна.
- Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөө 6,921.6 сая төгрөг төвлөрүүлэхээс 4,215.5 сая төгрөг төвлөрүүлж, 60.9 хувийн гүйцэтгэлтэй 2,706.1 сая төгрөгөөр тасарсан нь орлогыг үндэслэлгүй төлөвлөсөнтэй холбоотой байна.
- Дуудлага худалдааны орлогын төлөвлөгөө 30,000.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 4,210.6 сая төгрөг төвлөрүүлж, 14.0 хувийн гүйцэтгэлтэй 25,789.4 сая төгрөгөөр тасарсан нь Газрын тухай хууль, Хот байгуулалтын тухай хуульд заасны дагуу аймаг, сумын хэмжээнд газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх асуудал газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, хот хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөнүүд хийгдээгүй нөхцөлд шийдвэрлэх боломжгүй болсон байна.
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн төлөвлөгөө 474.9 сая төгрөг төвлөрүүлэхээс 404.6 сая төгрөг төвлөрүүлж, 85.2 хувийн гүйцэтгэлтэй 70.3 сая төгрөгөөр тасарсан нь Өргөн, Хатанбулаг сумдууд дутуу төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн төлөвлөлт

Тус аймгийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 42,438.7 сая төгрөг, орон нутгийн төсвийн орлогоос 43,455.8 сая төгрөг, нийт зарлагыг 85,894.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 40,886.1 сая төгрөгөөр бууруулж, 45,008.4 сая төгрөгөөр хянасан байна.

3.5.3 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг тодотголоор 25,257.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 36 хөтөлбөр, арга хэмжээг 196,196.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 112,544.6 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 40,852.2 сая төгрөг, үйл ажиллагааны орлого 1,399.8 сая төгрөг нийт 154,796.6 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр бүртгэж, нийт 153,358.5 сая төгрөгийн зардлын гүйцэтгэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 153,358.5 сая төгрөг буюу 79.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагаа зардлын төсвийг нийт 38,586.5 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна. Үүнд:

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
1	70105-Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	4,948.5	4,675.0	273.5	94.5
2	70709-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	6,996.6	2,828.4	4,168.2	40.4
3	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	101,826.6	84,751.5	17,075.1	83.2
4	70204-Санхүүгийн зах зээлийн зохицуулалт	200.0	200.0	-	100
5	70426-Төрийн өмчийг хэрэгжүүлэх	974.6	647.7	326.9	66.5
6	70418-Худалдан авах ажиллагаа	405.2	371.0	34.2	91.6

7	70429-Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	606.1	521.5	84.6	86.0
8	70501-ОН төсөвт олгох ОШилжүүлэг		1.4	-1.4	
9	70601-Зэвсэгт хүчний үйл ажиллагаа	248.2	247.7	0.5	99.8
10	70602-Хил хамгаалах	340.0	336.7	3.3	99.0
11	70708-Гамшгаас хамгаалах	4,556.5	3,162.7	1,393.8	69.4
12	70801-Мал аж ахуйг хөгжүүлэх	1,130.9	1,093.0	37.9	96.6
13	71403-Ойжуулалт	705.3	608.4	96.9	86.3
14	71405-Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт	910	910.0	-	100
15	71406-Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол	1,495.2	1,266.3	228.9	84.7
16	71411-Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	203.5	108.1	95.4	53.1
17	71413-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	2,276.2	1,677.3	598.9	73.7
18	71502-Хот байгуулалт, тохижуулалт	24,460.7	15,674.1	8,786.6	64.1
19	71601-Нийгмийн эрүүл мэнд	4,716.4	3,704.7	1,011.7	78.5
20	71602-Эмнэлгийн тусламж үйлчилгээ	2,631.8	2,384.1	247.7	90.6
21	71902-Нийгмийн халамж	146.4	90.2	56.2	61.6
22	71701-Биеийн тамир, спорт	3,082.2	2,953.7	128.5	95.8
23	71702-Соёл урлаг	7,141.8	3,823.1	3,318.7	53.5
24	71801-Сургуулийн өмнөх боловсрол	3,238.5	2,958.0	280.5	91.3
25	71802-Ерөнхий боловсрол	12,076.7	10,492.5	1,584.2	86.9
26	71804-Мэргэжлийн боловсрол	306.3	262.8	43.5	85.8
27	72101-Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	2,000.0	2,169.3	-169.3	108.5
28	72201-Жендерийн тэгш байдлыг хангах	2.8	2.8	-	100
29	72206-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгаалал	1,069.2	238.4	830.8	22.3
30	72207-Хүүхдийн хөгжил, хамгаалал	15.0	8.3	6.7	55.3
31	72208-Ахмад настны хөгжил, хамгаалал	360.5	141.6	218.9	39.3
32	72209-Залуучууд болон оюутнууд	15.0	15.0	-	100
33	72212-Гэр бүлийн хөгжил, хамгаалал	135.0	128.9	6.1	95.5
34	72301-Ангилалдаагүй бусад	190.0	168.8	21.2	88.8
35	71101-Автозам	6,207.1	4,735.4	1,471.7	76.3
36	70203-Засгийн газрын өрийн үйлчилгээ	577.7	-	577.7	-
НИЙТ ДҮН		196,196.5	153,358.4	42,838.1	78.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын илрүүлэлт:

Замын-Үүд сумын ЗДТГ- Албан томилолтоор ажилласан 28 ажилтанд хоолны мөнгө 1.5 сая төгрөгийг давхардуулж олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Чандмань-Илч ОНӨХХК- Шинэ жилийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотойгоор байгууллагын төсвөөс 1.9 сая төгрөгөөр дарс, оргилуун дарс, худалдан авсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Өргөн сумын ЗДТГ- Тайлант онд 2.9 сая төгрөгийн цалин хөлсийг үндэслэлгүйгээр илүү тооцож олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Хөвсгөл сумын ОНХС- ИТХ-ын тогтоолоор батлаагүй 4.3 сая төгрөгийн өртөгтэй нэг ажлыг ОНХС-аас санхүүжүүлсэн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Даланжаргалан сумын ЗДТГ- "Малчдаа тусалъя" аяны хүрээнд нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар нэг иргэнээс 5.5 сая төгрөгийн мөнгөн хандив хүлээн авч, холбогдох дансанд шилжүүлээгүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Хатанбулаг сумын ОНХС- Аймгийн ХО-аар хийгдсэн ажлын санхүүжилт 20.9 сая төгрөгийг ОНХС-аас санхүүжүүлсэн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Замын-Үүд сумын ИТХ- Тайлант онд Замын-Үүд сумын ИТХ-ын 1, 2, 3, 4, 5 дугаар тойргийн төлөөлөгчид Замын-Үүд сум байгуулагдсаны 30 жилийн ойн баяр наадамд 10.0 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас, гадаад албан уулзалтад зориулж 1.2 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйлийг бараа үйлчилгээний бусад зардлаас, нийт 11.2 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Дэлгэрэх сумын ЗДТГ- Байгууллагын төрийн үйлчилгээний 11 албан хаагчдад хууль тогтоомжид нийцээгүй нийт 10.3 сая төгрөгийн мөнгөн дэмжлэгийг цалингийн зардлаас олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Чандмань-Илч ОНӨХХК- 2023.11.13-ны өдрийн 136/ШШ2023/00524 дугаар шүүгчийн захирамжаар 1 ажилтныг хууль бусаар ажлаас халсан нь тогтоогдож, ажилгүй байсан хугацааны цалинг гаргуулахаар шийдвэрлэсэн ба 2024 оны 2 дугаар сард тус захирамжийн хэрэгжилтийг хангаж ажилгүй байсан хугацааны цалин 10.5 сая төгрөгийг байгууллагын төсвөөс олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Замын-Үүд сумын ЗДТГ- Тайлант хугацаанд цалингийн зардлаас гэрээт малчинд 8.9 сая төгрөгийн цалин олгосон зөрчилд зөвлөмж өгсөн.

Замын-Үүд сумын Засаг дарга- Тайлант онд “Ээлтэй Замын-Үүд” хөтөлбөрийн хүрээнд сумын төсөвт байгууллагуудын албан хаагчдад 2024 онд нийт 677.1 сая төгрөг олгосон байна. Урамшууллыг хуваарилахдаа ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын төсвийг шийдвэрлээгүй зөрчилд зөвлөмж өгсөн.

Хөвсгөл сумын Засаг дарга- Төсвийн гүйцэтгэлийн тайланд мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлийг 6.4 сая төгрөгөөр дутуу тайлагнасан алдааг аудитаар залруулсан.

Сайншанд сумын ЗДТГ- Сар бүрийн нийт бодогдсон цалин суутгалууд, гарт олгох дүн зэргийг түүвэрлэн нэгтгэж, НДШ-ийн тайлан, шилжүүлсэн зардлын дүнтэй нэг бүрчлэн тулган баталгаажуулахад НББ-ийн данс хөтлөлттэй холбоотой дараах алдаа илэрлээ. Үүнд: Цалингийн зардлыг 10.1 сая төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийг 0.04 сая төгрөгөөр тус тус илүү, НДШ-ийн өглөгийг 0.2 сая төгрөгөөр, Ажилчидтай холбоотой авлагыг 1.5 сая төгрөгөөр, ХХОАТ-ын өглөгийн 0.2 сая төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан алдааг аудитаар залруулсан.

3.5.4 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 9.1 сая төгрөг, ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 2,820.6 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,836.8 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 16,979.8 сая сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс: Цалин хөлс 1.5 сая төгрөг, байр ашиглалтай холбоотой тогтмол зардал 12.1 сая төгрөг, хангамж бараа материалын зардал 176.5 сая төгрөг, нормативт зардал 8.3 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 73.2 сая төгрөг, томилотт, зочны зардал 24.8 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал 17,979.6 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 2,699.9 сая төгрөг, бусад урсгал шилжүүлэг 10.5 сая төгрөг, хөрөнгийн зардал 414.7 сая төгрөгийг тус тус зарцуулж, үлдэгдэл 1,245.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

Аудитын илрүүлэлт:

Аймгийн ЗДТГ- Тайлант онд “Бадрах Энержи” компани болон компанийн дийлэнх хувьцаа эзэмшигч “Орано Майнинг” компаниас мал аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилт хүндэрч аймгийн нийт нутгаар зудын нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан малын зүй бус хорогдол ихээр гарч эрсдэлд орсон малчин өрхүүдийн амьжиргааг дэмжих зорилгоор 300.0 сая төгрөгийн хандивын орлогыг аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авч, зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд нийт 9 хөтөлбөрийн хүрээнд 3,626.6 сая төгрөгийн төсвийг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 3,585.6 сая төгрөгийг зарцуулж, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц 86.7 хувьтай дүгнэгдсэн байна.

Хүснэгт 11. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр (дэд хөтөлбөр)	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	/сая төгрөгөөр/		
				Хэрэгж ил тийн явц (хувь)	Зарцуу лах төсөв	Зарцуу лсан
1	“Төрийн захиргааны албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн батлагааг хангах” зорилтот хөтөлбөр	2023-2026	Төрийн бодлого, чиг үүргийг үр ашиг, үр нөлөөтэй боловсруулж, хэрэгжүүлэх болон төрийн алба, өөрчлөлт шинэчлэлтэд зохицож чадах үнэт зүйл, мэдлэг, чадвар бүхий хүний нөөцийг төлөвшүүлэх, тэдгээрийн ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор боловсруулан хэрэгжүүлж буй “Дорноговь аймгийн төрийн захиргааны албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах”	84.8	615.5	601.4
2	“Англи хэлтэй Дорноговь” зорилтот хөтөлбөр	2021-2025	Англи хэлний сургалтын төв, клубүүд нь хүүхдүүдийн сонирхолд нийцүүлэх байдлаар өсвөр насны хүүхдүүдийн сэтгэхүйн онцлог, сонирхолд нь нийцсэн олон төрлийн арга барилаар үйл ажиллагаагаа явуулж хэвшсэн. Англи хэлний сургалтын төв, клуб нь 2024 оны байдлаар 12 болж 3857 хүүхэд хамруулсан нь өмнөх оноос өссөн байх	87.2	25.5	24.6
3	“Хүүхдэд ээлтэй орон нутаг” зорилтот хөтөлбөр	2021-2025	Хүүхэд эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, хүүхэд хамгааллын тогтвортой үр дүнд хүрэх	88.3	190.1	183.9
4	“Монгол малчин” дэд хөтөлбөр	2020-2024	Малчдыг мэдээллээр хангах, хөгжүүлэх, орон нутагтаа ая тухтай ажиллах, амьдрах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, бүтээмж, орлого, ашгийг нь өсгөх, тэдгээрийг чадавхжуулах	89.2	19.9	19.9
5	“Нээлттэй Дорноговь аймаг” зорилтот хөтөлбөр	2023-2024	Орон нутагт шилжин тогтвор суурьшилтай амьдарч, ажиллах гэр бүл, өрхөд чиглэсэн эдийн засгийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх	88.9	311.0	307.9
6	“Цахим Дорноговь” хөтөлбөр	2023-2026	“Ухаалаг засаглал” төрийн дотоод үйл ажиллагааг цахимжуулж уялдаа холбоог сайжруулах, төр, иргэн, аж ахуй нэгж хоорондын мэдээллийн урсгалыг сайжруулах, кибер аюулгүй байдлыг хангасан чадварлаг боловсон хүчнийг бэлтгэж нэгдсэн удирдлагын платформыг бий болгож ухаалаг засаглалын тогтолцоо бүрдүүлэх	76.4	38.7	29.4

7	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх зорилтот хөтөлбөр	2021-2025	Иргэдийн амьдарч буй орчны тохижилтыг сайжруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг олон нийтийн оролцоонд тулгуурлан зохион байгуулах, хамтын ажиллагааны үр дүнд “Ногоон Дорноговь” аймгийг бий болгох	91.8	76.7	76.7
8	“Анагаахын боловсрол олгох сургалтын байгууллагын хөгжлийг дэмжих” хөтөлбөр	2024-2027	Орон нутагт их сургуулийн цогцолборыг жишиг байдлаар хөгжүүлж, шинжлэх ухаан, боловсрол, эрүүл мэндийн салбарт манлайлагч их сургууль болгоход дэмжлэг үзүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино	74.0	349.8	345.6
9	“Түншлэл ба хөгжил” бизнес эрхлэгчдийг дэмжих аймгийн зорилтот хөтөлбөр	2024-2027	Бүс нутгийн онцлог, дэд бүтцийн давуу тал, түүхий эдийн нөөцөд тулгуурлан бичил, жижиг, дунд үйлдвэр, худалдаа үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг тогтвортой хөгжүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээний цар хүрээг өргөжүүлэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний цар хүрээг өргөжүүлэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, хэмжээ, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, импортыг орлох, экспортод чиглэсэн нутгийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгох	99.8	1,999.4	1,996.2
Нийт дүн				86.7	3,626.6	3,585.6

Орон нутгийн төсвийн байгууллагуудаас ерөнхий чиглэлийн дагуу авсан судалгаа

Хүснэгт 12. Судалгааны гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Сумдын нэрс	Ахмадын сангийн үлдэгдэл	Худалдан авах ажиллагаа	Бараа үйлчилгээний бусад 210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 210901
1	Айраг	45.68	122,724.39	21,313.98	5,137.99
2	Алтанширээ	8.40	1,612.76	624.28	37.32
3	Даланжаргалан	12.45	880.25	802.76	9.26
4	Дэлгэрэх	-	24.86	306.00	16.49
5	Иххэт	-	-	290.11	9.47
6	Мандах	4.54	1,628.78	8,607.34	615.14
7	Өргөн	-	1,325.46	551.59	20.95
8	Сайхандулаан	19.94	1,118.85	306.52	13.65
9	Улаанбадрах	6.11	3,065.78	3,402.92	2,557.23
10	Хатанбулаг	14.57	494.78	28.32	309.42
11	Хөвсгөл	7.30	-	70.26	881.30
12	Эрдэнэ	18.30	-	1,066.12	216.46
13	Сайншанд	6.42	1,061.94	196.02	457.56
14	Замын-Үүд	9.81	544.27	299.75	9.27
15	Дорноговь шууд	5.94	1.52	272.08	420.15
Нийт		159.46	134,483.64	38,138.05	10,711.66

-Ахмадын сан:

ТЕЗ-ийн харьяа 54 байгууллагаас 35 байгууллага ахмадын сантай бөгөөд эхний үлдэгдэл 148.3 сая төгрөг, тайланд онд 76.9 сая төгрөгийн орлого төвлөрч, 65.8 зарлагын гүйлгээ хийгдэж, ахмадын сан нийт 159.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

-Худалдан авах ажиллагаа:

Тайлант онд 19 байгууллага 134,483.6 сая төгрөгийн 174 худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.

-Төсвөөс 2024 онд зарцуулсан бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж (210801):

Тайлант онд бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас нийт 38,138.0 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Сайншанд сумын ЗАА- Тайлант онд 414.8 сая төгрөгийн 89 гүйлгээ хийгдсэнээс 16.2 сая төгрөгийн 2 гүйлгээг зардлын зориулалт бусаар зарцуулсан зөрчилд албан шаардлага өгсөн.

-Төсвөөс 2024 онд зарцуулсан бараа үйлчилгээний бусад зардал (210901):

Тайлант онд бараа үйлчилгээний зардлаас нийт 10,711.6 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

-Байгууллагын 2024 оны орон тооны судалгаа:

Тайлант онд нийт 44 байгууллага 1405 хүний орон тоо батлагдсанаас 1270 хүний гүйцэтгэлтэй ажилласан байна. ТЭЗ-ийн харьяа нийт 7 байгууллага 13 орон тоо хэтрүүлсэн ажилласан, нийт 26 байгууллага 148 орон тоо дутуу ажиллаж 1,277.0 сая төгрөгийн хэмнэлт үүсгэсэн байна.

Орон нутгийн өмчит газруудын ашиг, алдагдал

Хүснэгт 13. Ашиг, алдагдал

					/сая төгрөгөөр/	
Д/д	Байгууллагын нэр	Орлого	Зардал	ААНОАТ	Ашиг алдагдал	
1	Борхойн баян бүрд	670.8	538.7	13.2	118.9	
2	Дорноговь Орон сууц	542.9	219.6	36.4	286.9	
3	Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газрын захиргаа	1,751.9	820.7	-	931.2	
4	Эм эргэлтийн сан	35.9	79.8	-	-43.9	
5	Дагшин-Эрдэнэ	142.2	216.6	-	-74.4	
6	Замын-Үүд НААҮ	1,615.8	1,986.4	-	-370.6	
7	Чандмань-Илч	27,421.5	28,622.6	0.4	-1,201.5	
8	Говь консалтинг менежмент	-	-	-	-	
9	Дорноговь байгалийн баялаг	-	-	-	-	
10	Их говийн хөгжлийн гарц	-	-	-	-	
	Нийт	32,181.0	32,484.4	50.0	353.4	

Алдагдалтай ажилласан шалтгааныг тодруулбал:

- Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ нь тайлант онд 74.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь ЭМД-ын санхүүжилтгүй ажиллаж, сувилуулагчдын тоо өмнөх оноос 280 хүнээр буюу 43 хувиар буурсан байна.
- Замын-Үүд НААҮ ОНӨХХК нь 2024 онд 370.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь үндсэн хөрөнгийн элэгдэл болон үндсэн хөрөнгө данснаас хассаны гарзаас шалтгаалсан байна.
- Чандмань-Илч ОНӨХХК нь 1,201.5 сая төгрөгийн алдагдалтай тайлагнасан нь тайлант жилийн элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, зөрчил давтан гаргахгүй байх талаар зөвлөмж, албан шаардлагуудыг тусгасан болно.

Аудитыг аудитор Т.Мөнхтогтох, Н.Мөнхнасан, А.Дамчой нар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор О.Нарангарав, аудитын менежер У.Оюунтүлхүүр, дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 01/573 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлого сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт орлогын 358,001.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 3,580.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2,685.0 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг зөрчсөн дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

Дэлгэрэх сумын ЗДТГ- Байгууллагын төрийн үйлчилгээний 11 албан хаагчдад хууль тогтоомжид нийцээгүй нийт 10.3 төгрөгийн мөнгөн дэмжлэгийг цалингийн зардлаас олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Чандмань-Илч ОНӨХХК- Тайлант хугацаанд алба, салбаруудад 13.6 сая төгрөгийн урамшуулал, шинэ жилийн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой ажилчдыг шагнахад 40.8 сая төгрөг, сугалааны хонжворт 2.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Замын-Үүд сумын ЗДТГ- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1.3, 4.2.6 дахь заалттай нийцэхгүй 43.4 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Хөвсгөл сумын ЗДТГ- Тайлант хугацаанд цэвэр бохир усны зардалд нийт 10.2 сая төгрөг зарцуулсан ба 6 дугаар сард 6.9 сая төгрөг, 12 дугаар сард 3.6 сая төгрөгийг зарцуулсан зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд 2024 онд оруулбал зохих 154 мэдээллээс хугацаандаа оруулсан 154 мэдээлэл, хөрөнгө зарцуулах тухай аймгийн Засаг даргын байршуулбал зохих 108,973.0 сая төгрөгийн 523 захирамжаас 9.0 сая төгрөгийн 2 захирамжийг мэдээлээгүй байна. Fas системээр шилэн дансны мэдээлэл оруулсан байдлын хэрэгжилтийг үнэлэхэд 99.6 хувьтай байна.

Нэгтгэлд хамрагдсан харьяа байгууллагуудад шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрч аудитаар холбогдох шийдвэрүүдийг хүргүүлсэн байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

Эрдэнэ сумын ИТХ- Тус байгууллагын Шилэн дансны цахим системд төсөв, өмч, хөрөнгө зарцуулах нийт 18.5 сая төгрөгийн 25 шийдвэрээс 15.0 сая төгрөгийн 23 шийдвэрийг хугацаа хоцроож, 3.5 сая төгрөгийн 2 шийдвэрийг огт мэдээлээгүй нь өмнөх онд зөвлөмжөөр өгсөн алдааг давтан гаргасан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Даланжаргалан сумын ЗДТГ- Шилэн дансны цахим системд тайлант хугацаанд оруулбал зохих цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын нийт 71.5 сая төгрөгийн 7 ажил гүйлгээнээс 11.6 сая төгрөгийн 1 гүйлгээ, хөрөнгө зарцуулах 15.0 сая төгрөгийн 14 тушаалаас 7.1 сая төгрөгийн 4 шийдвэрийг мэдээлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Эрдэнэ сумын ЗДТГ- Тус байгууллагын Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 313.0 сая төгрөгийн мэдээллүүдээс 130.9 сая төгрөгийн зарлагын 13 гүйлгээ, 28.3 сая төгрөгийн 37 шийдвэрийг мэдээлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Чандмань-Илч ОНӨХХК- Тус байгууллага нь тайлант хугацаанд хөрөнгө зарцуулах нийт 534.5 сая төгрөгийн 58 тушаал шийдвэрээс 411.9 сая төгрөгийн 30 тушаалыг мэдээлээгүй, 122.6 сая төгрөгийн 28 тушаалыг хугацаа хоцроож байршуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Хөвсгөл сумын ЗДТГ- Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон болон мэдээлээгүй, өмнөх оны зөрчил давтан гарсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар ТЕЗ-ийн санхүүгийн тайланд 5 горим сорил хэрэгжүүлж төлөвлөгөөг батлуулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 14. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	1	-	1	-	100
Зөвлөмж	1	-	1	-	100
Нийт дүн	2	-	2	-	100

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг Төрийн аудитын газарт 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 02/1367 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. УТХО-аар хэрэгжсэн ТАХ-ний зардалд орон нутгийн төсвөөс 2022 онд 8,177.1 сая төгрөг, 2023 онд 3,755.0 сая төгрөг, нийт 11,932.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 2022 онд орон нутгийн төсвөөс олгосон 1,047.2 сая төгрөгийг 2023 оны Төсвийн тухай хуулиар баталж, орон нутгийн төсөвт нөхөн олгосон байна.

2. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 481 дүгээр тогтоолоор "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын Хот хөдөөгийн сэргэлтийн зорилтыг хэрэгжүүлэх, хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах зорилгоор 2024 оныг "Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил" болгон зарласантай холбоотой Аймгийн засаг даргын 2024 оны А/01 дүгээр захирамжаар 2024 оныг "Түншлэл-Хөгжил" жил болгон зарласан. Жилийн зорилтыг хангах үүднээс аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих ажлын хүрээнд орон нутгийн орлогоос бизнес эрхлэгчдийг дэмжих төслийн 1,952.9 сая төгрөгийн зээлийг 18 иргэн 8 ААН-д олгосон байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 43 төсвийн байгууллага, 10 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 30 тусгай сан, 14 төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлан, нийт 97 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 97 байгууллага аудитад хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 48 байгууллагыг түүвэрт хамруулж, 49 байгууллагад дүгнэлт гаргаж “Өөрчлөлтгүй” 37, “Өөрчлөлттэй” 12 дүгнэлтийг хүргүүлсэн байна.

ТЭЗ-ийн харьяа байгууллагуудад санхүүгийн тайлангийн аудитаар нийт 35,051.3 сая төгрөгийн 294 алдаа, зөрчил илрүүлснээс 33,683.6 сая төгрөгийн 181 алдааг залруулж, 41.6 сая төгрөгийн зөрчилд 15 төлбөрийн акт тогтоож, 621.6 сая төгрөгийн зөрчилд 55 албан шаардлага, 704.5 сая төгрөгийн зөрчилд 37 зөвлөмж, хариуцлага тооцуулах 6 албан шаардлага хүргүүлсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Аудитаар нийт 5,120.9 сая төгрөгийн 18 алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 5,120.9 сая төгрөгийн 15 алдааг залруулж, 1 албан шаардлага, 2 зөвлөмжийг хүргүүлсэн байна. 10 төсвийн төвлөрүүлэн захирагчид өөрчлөлтгүй дүгнэлт, 4 өөрчлөлттэй дүгнэлт өгсөн байна.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн шууд захирагчийн 43 байгууллагаас 16 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 27 дүгнэлт өгсөн байна. Үүнээс: өөрчлөлтгүй 19, өөрчлөлттэй 8 дүгнэлтийг хүргүүлсэн байна.

Аудитаар нийт 11,678.5 сая төгрөгийн 177 алдаа, зөрчил илрүүлснээс 11,116.2 сая төгрөгийн 105 алдааг залруулж, 14.3 сая төгрөгийн зөрчилд 11 төлбөрийн акт тогтоож, 346.5 сая төгрөгийн зөрчилд 38 албан шаардлага, 201.5 сая төгрөгийн зөрчилд 18 зөвлөмж, хариуцлага тооцуулах 5 албан шаардлага хүргүүлсэн.

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа орон нутгийн өмчит 10 аж ахуйн нэгж байгууллагаас 3 байгууллага түүвэрт хамрагдаж, 7 байгууллагад дүгнэлт өгсөн байна. Үүнээс өөрчлөлтгүй 7 дүгнэлтийг хүргүүлсэн байна.

Аудитаар нийт 618.0 сая төгрөгийн 21 алдаа, зөрчил илрүүлснээс 54.0 сая төгрөгийн 5 алдааг залруулж, 1.9 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 70.2 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага, 491.9 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлсэн. өгсөн.

Тусгай санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа 30 сангийн 29 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 1 сангийн санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргасан. Үүнээс өөрчлөлтгүй 1 дүгнэлтийг хүргүүлсэн байна.

Аудитаар нийт 17,633.9 сая төгрөгийн 78 алдаа, зөрчил илрүүлснээс 17,392.6 сая төгрөгийн 56 алдааг залруулж, 25.3 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 204.9 сая төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага, 11.1 сая төгрөгийн зөрчилд 11 зөвлөмж өгсөн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Аудитаар нийт 11,897.5 сая төгрөгийн 3 алдаа илэрснээс аудитын явцад залруулсан. Үүнд:

1. Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагын аудит хийгдсэн тайланг 9,059.7 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн байсныг аудитын явцад залруулав.

2. Санхүүгийн нэгтгэсэн тайланд “Түншлэл ба хөгжил” зорилтот хөтөлбөрийн төслийн санхүүжилт болох 1,877.9 сая төгрөгийг авлагаар тусгалгүй үр дүнгээр тусгасан байсныг аудитын явцад залруулав.

3. Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөг 959.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг аудитын явцад залруулав.

Аудитаар нийт 175.9 сая төгрөгийн 4 зөрчил илрүүлж, 175.9 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2023 оны 15/10 дугаар “Дуудлагаар худалдах аргаар хувьчлах тухай” тогтоолоор татан буугдах шийдвэр гарсан боловч 2025 онд дуудлага худалдаа зарласан бөгөөд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажил удаашралтай хангалтгүй байна.

Энэ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2-д “Аймгийн Засаг дарга нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2023 оны 15/10 дугаар “Дуудлагаар худалдах аргаар хувьчлах тухай” тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах.

2. Тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй орон нутгийн өмчит 3 газар (Говь консалтинг менежмент, Дорноговь байгалийн баялаг, Их говийн хөгжлийн гарц)-т шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5-д “Аймгийн Засаг дарга нь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлнэ”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй орон нутгийн өмчит 3 газар (Говь консалтинг менежмент, Дорноговь байгалийн баялаг, Их говийн хөгжлийн гарц)-т шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн хэрэгжилтийг 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

5.2 Албан шаардлага

1. Тайлант хугацаанд орон нутгийн төсвийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас 3 ажилд 125.5 сая төгрөгийн зардал гаргасан боловч худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

Энэ нь бэлтгэн нийлүүлэгчдийн өрсөлдөх тэгш боломжтой байх, төсвийн ил тод, үр ашигтай хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг алдагдуулж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-д *“Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно”* гэж заасантай нийцэхгүй байна.

2. Аймгийн ИТХ-аар батлагдсан төсвөөр Улаанбадрах суманд 558.1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг аймгийн төсвөөс олгохоор батлагдсан байхад гүйцэтгэлээр 608.4 сая төгрөгийн санхүүжилт буюу 50.4 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон байна.

Энэ нь үр ашигтай хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг алдагдуулж, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д *“Бүх шатны төсвийн захирагч батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах үүрэг хүлээнэ”*, 42 дугаар зүйлийн 42.2.1б *“Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөвтөө түүнд шууд харьяалагдах төвлөрүүлэн захирагчдын төсөв хооронд зохицуулалт хийж болно”* гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Дорноговь аймгийн ТЕЗ	3	11,897.49	1	1,877.96	2	10,019.53	3	11,897.49				
2	Айраг сумын Засаг дарга	2	2,135.20	-	-	2	2,135.20	2	2,135.20	-	-	-	-
3	Айраг сумын ЗДТГ	2	3.63	-	-	2	3.63	2	3.63	-	-	-	-
4	Айраг сумын ОНХС	2	1,094.88	-	-	2	1,094.88	2	1,094.88	-	-	-	-
5	Айраг сумын ХХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
6	Алтанширээ сумын Засаг дарга	2	1,322.86	-	-	2	1,322.86	2	1,322.86	-	-	-	-
7	Алтанширээ сумын ЗДТГ	5	1,077.95	1	1.00	4	1,076.95	5	1,077.95	-	-	-	-
8	Алтанширээ сумын ХХС	2	22.68	1	11.57	1	11.11	2	22.68	-	-	-	-
9	Алтанширээ сумын ОНХС	4	1,188.90	1	881.15	3	307.75	4	1,188.90	-	-	-	-
10	Даланжаргалан сумын ЗДТГ	3	107.00	1	0.45	2	106.55	3	107.00	-	-	-	-
11	Даланжаргалан сумын ИТХ	1	3.95	-	-	1	3.95	1	3.95	-	-	-	-
12	Даланжаргалан сумын ОНХС	4	1,767.03	-	-	4	1,767.03	4	1,767.03	-	-	-	-
13	Даланжаргалан сумын ХХС	3	6.61	2	5.34	1	1.27	3	6.61	-	-	-	-
14	Дэлгэрэх сумын Засаг дарга	1	182.58	-	-	1	182.58	1	182.58	-	-	-	-
15	Дэлгэрэх сумын ЗДТГ	1	0.38	1	0.38	-	-	1	0.38	-	-	-	-
16	Дэлгэрэх сумын ИТХ	1	1.80	1	1.80	-	-	1	1.80	-	-	-	-
17	Дэлгэрэх сумын ОНХС	1	7.50	-	-	1	7.50	1	7.50	-	-	-	-
18	Иххэт сумын Засаг дарга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
19	Иххэт сумын ЗДТГ	3	796.49	1	16.00	2	780.49	3	796.49	-	-	-	-
20	Иххэт сумын ОНХС	3	97.26	-	-	3	97.26	3	97.26	-	-	-	-
21	Иххэт сумын ХХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
22	Мандах сумын Засаг дарга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
23	Мандах сумын ЗДТГ	1	57.48	-	-	1	57.48	1	57.48	-	-	-	-
24	Мандах сумын ИТХ	3	8.37	1	2.30	2	6.07	3	8.37	-	-	-	-
25	Мандах сумын ОНХС	3	1,175.53	1	1,158.85	2	16.68	3	1,175.53	-	-	-	-
26	Мандах сумын ХХС	1	1.53	-	-	1	1.53	1	1.53	-	-	-	-
27	Өргөн сумын Засаг дарга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
28	Өргөн сумын ЗДТГ	5	70.02	1	3.82	4	66.20	5	70.02	-	-	-	-
29	Өргөн сумын ИТХ	2	30.20	-	-	2	30.20	2	30.20	-	-	-	-
30	Өргөн сумын ОНХС	1	749.97	-	-	1	749.97	1	749.97	-	-	-	-
31	Өргөн сумын ХХС	2	10.29	2	10.29	-	-	2	10.29	-	-	-	-
32	Сайхандулаан сумын Засаг дарга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

33	Сайхандулаан сумын ЗДТГ	3	1,205.16	1	70.84	2	1,134.32	3	1,205.16	-	-	-	-
34	Сайхандулаан сумын ИТХ	3	162.41	1	0.00	2	162.41	3	162.41	-	-	-	-
35	Сайхандулаан сумын ОНХС	2	566.85	1	1.58	1	565.27	2	566.85	-	-	-	-
36	Сайхандулаан сумын ХХС	3	20.94	3	20.94	-	-	3	20.94	-	-	-	-
37	Улаанбадрах сумын Засаг дарга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
38	Улаанбадрах сумын ЗДТГ	3	364.95	-	-	3	364.95	3	364.95	-	-	-	-
39	Улаанбадрах сумын ИТХ	2	19.20	-	-	2	19.20	2	19.20	-	-	-	-
40	Улаанбадрах сумын ОНХС	3	1,124.38	3	1,124.38	-	-	3	1,124.38	-	-	-	-
41	Улаанбадрах сумын ХХС	1	1.72	1	1.72	-	-	1	1.72	-	-	-	-
42	Хатанбулаг сумын Засаг дарга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
43	Хатанбулаг сумын ЗДТГ	3	2,975.73	2	2,326.98	1	648.75	3	2,975.73	-	-	-	-
44	Хатанбулаг сумын ИТХ	3	3.13	-	-	3	3.13	3	3.13	-	-	-	-
45	Хатанбулаг сумын ОНХС	4	3,655.44	-	-	4	3,655.44	4	3,655.44	-	-	-	-
46	Хатанбулаг сумын ХХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
47	Хөвсгөл сумын Засаг дарга	5	121.10	-	-	5	121.10	5	121.10	-	-	-	-
48	Хөвсгөл сумын ЗДТГ	4	15.16	1	4.37	3	10.79	4	15.16	-	-	-	-
49	Хөвсгөл ИТХ	2	2.31	-	-	2	2.31	2	2.31	-	-	-	-
50	Хөвсгөл сумын ОНХС	1	666.91	-	-	1	666.91	1	666.91	-	-	-	-
51	Хөвсгөл сумын ХХС	2	15.66	-	-	2	15.66	2	15.66	-	-	-	-
52	Эрдэнэ сумын Засаг дарга	4	695.68	-	-	4	695.68	4	695.68	-	-	-	-
53	Эрдэнэ сумын ЗДТГ	4	51.72	1	0.60	3	51.12	4	51.72	-	-	-	-
54	Эрдэнэ сумын ИТХ	3	9.15	-	-	3	9.15	3	9.15	-	-	-	-
55	Эрдэнэ сумын ОНХС	2	684.27	1	544.27	1	140.00	2	684.27	-	-	-	-
56	Эрдэнэ сумын ХХС	2	4.67	-	-	2	4.67	2	4.67	-	-	-	-
57	Сайншанд сумын Засаг дарга	1	663.43	-	-	1	663.43	1	663.43	-	-	-	-
58	Сайншанд сумын ЗДТГ	4	108.19	-	-	4	108.19	4	108.19	-	-	-	-
59	Сайншанд сумын ИТХ	2	8.35	-	-	2	8.35	2	8.35	-	-	-	-
60	Сайншанд сумын ОНХС	3	2,490.47	1	652.10	2	1,838.37	3	2,490.47	-	-	-	-
61	Сайншанд сумын ХХС	1	0.05	-	-	1	0.05	1	0.05	-	-	-	-
62	Сайншанд сумын ЗАА	3	530.19	-	-	3	530.19	3	530.19	-	-	-	-
63	Сайншанд сумын Зүүнбаян багийн Тохжилт	4	8.12	-	-	4	8.12	4	8.12	-	-	-	-
64	Замын-Үүд сумын Засаг дарга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
65	Замын-Үүд сумын ЗДТГ	5	44.35	-	-	5	44.35	5	44.35	-	-	-	-
66	Замын-Үүд сумын ИТХ	1	0.03	-	-	1	0.03	1	0.03	-	-	-	-
67	Замын-Үүд сумын ЗАА	2	29.12	-	-	2	29.12	2	29.12	-	-	-	-
68	Замын-Үүд сумын ОНХС	2	1,536.51	-	-	2	1,536.51	2	1,536.51	-	-	-	-
69	Замын-Үүд сумын ХХС	2	9.30	-	-	2	9.30	2	9.30	-	-	-	-
70	Борхойннاران ЗГБХН	6	1,037.71	2	984.20	4	53.51	6	1,037.71	-	-	-	-

71	Аймгийн ИТХ	5	30.71	1	27.28	4	3.43	5	30.71	-	-	-	-
72	Аймгийн ЗДТГ	1	18.00	-	-	1	18.00	1	18.00	-	-	-	-
73	Аймгийн ОНХС	2	493.29	2	493.29	-	-	2	493.29	-	-	-	-
74	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	1	0.21	-	-	1	0.21	1	0.21	-	-	-	-
75	Орон нутгийн өмчийн газар	3	25.87	-	-	3	25.87	3	25.87	-	-	-	-
76	Байгаль орчны газар	7	1,881.62	-	-	7	1,881.62	7	1,881.62	-	-	-	-
77	Нийтлэг үйлчилгээний газар	4	427.55	-	-	4	427.55	4	427.55	-	-	-	-
78	Худалдан авах ажиллагааны газар	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
79	Борхойн баян бүрд	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
80	Чандмань Илч ОНӨХХК	2	29.51	-	-	2	29.51	2	29.51	-	-	-	-
81	Дорноговь Орон сууц ОНӨААТҮГ	1	1.76	-	-	1	1.76	1	1.76	-	-	-	-
82	Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ	2	22.69	-	-	2	22.69	2	22.69	-	-	-	-
Нийт дүн		184	45,581.15	36	10,223.46	148	35,357.69	184	45,581.15	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Үүнээс											
		Нийт зөрчил		Зөвлөмж		Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Дорноговь аймгийн ТЕЗ	4	175.91	2	-	-	-	2	175.91	-	-	-	-
2	Айраг сумын Засаг дарга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
3	Айраг сумын ЗДТГ	1	0.24	-	-	-	-	1	0.24	-	-	-	-
4	Айраг сумын ИТХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
5	Айраг сумын ОНХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
6	Айраг сумын ХХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
7	Алтанширээ сумын Засаг дарга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
8	Алтанширээ сумын ЗДТГ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
9	Алтанширээ сумын ИТХ	1	0.24	1	0.24	-	-	-	-	-	-	-	-
10	Алтанширээ сумын ОНХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
11	Алтанширээ сумын ХХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
12	Даланжаргалан сумын Засаг дарга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
13	Даланжаргалан сумын ЗДТГ	3	6.52	1	1.02	1	5.50	1	-	-	-	-	-
14	Даланжаргалан сумын ИТХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
15	Даланжаргалан сумын ОНХС	1	13.69	-	-	-	-	1	13.69	-	-	-	-
16	Даланжаргалан сумын ХХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
17	Дэлгэрэх сумын Засаг дарга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
18	Дэлгэрэх сумын ЗДТГ	4	4.03	-	-	2	1.45	1	2.58	1	1	-	-
19	Дэлгэрэх сумын ИТХ	2	0.23	1	-	1	0.23	-	-	-	-	-	-
20	Дэлгэрэх сумын ОНХС	3	102.37	1	11.06	-	-	2	91.31	-	-	-	-
21	Дэлгэрэх сумын ХХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
22	Иххэт сумын Засаг дарга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
23	Иххэт сумын ЗДТГ	1	2.86	-	-	-	-	1	2.86	-	-	-	-
24	Иххэт сумын ИТХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
25	Иххэт сумын ОНХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
26	Иххэт сумын ХХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
27	Мандах сумын Засаг дарга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
28	Мандах сумын ЗДТГ	2	2.86	1	0.92	-	-	1	1.94	-	-	-	-
29	Мандах сумын ИТХ	1	0.53	1	0.53	-	-	-	-	-	-	-	-
30	Мандах сумын ОНХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
31	Мандах сумын ХХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

32	Өргөн сумын Засаг дарга	1	-	-	-	-	-	1	-	-	-	-
33	Өргөн сумын ЗДТГ	5	129.50	-	-	2	3.86	2	125.65	1	1	-
34	Өргөн сумын ИТХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
35	Өргөн сумын ОНХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
36	Өргөн сумын ХХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
37	Сайхандулаан сумын Засаг дарга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
38	Сайхандулаан сумын ЗДТГ	3	7.74	-	-	-	-	3	7.74	-	-	-
39	Сайхандулаан сумын ИТХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
40	Сайхандулаан сумын ОНХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
41	Сайхандулаан сумын ХХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
42	Улаанбадрах сумын Засаг дарга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
43	Улаанбадрах сумын ЗДТГ	4	12.84	-	-	-	-	3	12.84	1	1	-
44	Улаанбадрах сумын ИТХ	2	6.11	-	-	-	-	1	6.11	1	1	-
45	Улаанбадрах сумын ОНХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
46	Улаанбадрах сумын ХХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
47	Хатанбулаг сумын Засаг дарга	1	-	1	-	-	-	-	-	-	-	-
48	Хатанбулаг сумын ЗДТГ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
49	Хатанбулаг сумын ИТХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
50	Хатанбулаг сумын ОНХС	1	20.94	-	-	1	20.94	-	-	-	-	-
51	Хатанбулаг сумын ХХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
52	Хөвсгөл сумын Засаг дарга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
53	Хөвсгөл сумын ЗДТГ	3	26.83	2	24.66	-	-	1	2.17	-	-	-
54	Хөвсгөл сумын ИТХ	3	21.77	-	-	1	0.30	2	21.47	-	-	-
55	Хөвсгөл сумын ОНХС	3	32.79	-	-	1	4.37	2	28.42	-	-	-
56	Хөвсгөл сумын ХХС	1	1.50	-	-	-	-	1	1.50	-	-	-
57	Эрдэнэ сумын Засаг дарга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
58	Эрдэнэ сумын ЗДТГ	1	0.51	-	-	-	-	1	0.51	-	-	-
59	Эрдэнэ сумын ИТХ	1	0.12	-	-	-	-	1	0.12	-	-	-
60	Эрдэнэ сумын ОНХС	3	70.00	-	-	-	-	3	70.00	-	-	-
61	Эрдэнэ сумын ХХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
62	Сайншанд сумын Засаг дарга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
63	Сайншанд сумын ЗДТГ	1	19.90	-	-	-	-	1	19.90	-	-	-
64	Сайншанд сумын ИТХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
65	Сайншанд сумын ОНХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
66	Сайншанд сумын ХХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
67	Сайншанд сумын ЗАА	1	16.33	-	-	-	-	1	16.33	-	-	-
68	Сайншанд сумын Зүүнбаян багийн ЗАА	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
69	Сайншанд сумын Зүүнбаян багийн Тохижилт	1	0.23	-	-	-	-	1	0.23	-	-	-
70	Замын-Үүд сумын Засаг дарга	1	-	1	-	-	-	-	-	-	-	-
71	Замын-Үүд сумын ЗДТГ	3	10.44	2	8.94	1	1.50	-	-	-	-	-

72	Замын-Үүд сумын ИТХ	3	11.95	1	-	1	0.76	1	11.18	-	-	-	-
73	Замын-Үүд сумын ОНХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
74	Замын-Үүд сумын ХХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
75	Замын-Үүд сумын ЗАА	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
76	Аймгийн ИТХ	2	-	1	-	-	-	1	-	-	-	-	-
77	Аймгийн ЗДТГ	2	-	1	-	-	-	-	-	1	1	-	-
78	Аймгийн ОНХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
79	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	2	3.06	-	-	1	0.26	1	2.80	-	-	-	-
80	Орон нутгийн өмчийн газар	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
81	Худалдан авах ажиллагааны газар	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
82	Байгаль орчны газар	1	6.45	-	-	-	-	1	6.45	-	-	-	-
83	Нийтлэг үйлчилгээний газар	1	137.10	1	137.10	-	-	-	-	-	-	-	-
84	Халамжийн сан орон нутаг	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
85	Агатова ЗГБХН	1	9.48	-	-	-	-	1	9.48	-	-	-	-
86	Талст зам ЗГБХН	1	4.47	-	-	-	-	1	4.47	-	-	-	-
87	Мишээлт мана ЗГБХН	1	18.40	-	-	-	-	1	18.40	-	-	-	-
88	Борхойн наран ЗГБХН	1	18.91	1	18.91	-	-	-	-	-	-	-	-
89	Дорноговь орон сууц	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
90	Их хөгжлийн гарц	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
91	Говь консалтинг менежмент	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
92	Дорноговь байгалийн баялаг	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
93	Чандмань Илч ХХК	5	15.12	1	-	1	1.90	2	13.22	1	1	-	-
94	Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК	1	-	1	-	-	-	-	-	-	-	-	-
95	Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
96	Борхойн баян бүрд ОНӨААТҮГ	3	491.98	2	491.89	1	0.09	-	-	-	-	-	-
97	Хамрын хийдийн тусгай хамгаалалттай газрын захиргаа ОНӨААТҮГ	5	-	2	-	-	-	3	-	-	-	-	-
98	Эм эргэлтийн сан ОНӨААТҮГ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн		91	1,403.95	25	695.27	14	41.16	46	667.52	6	6	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Айраг сумын ОНХС	1	-	-	-	-	-	1	-
2	Алтанширээ сумын ОНХС	1	-	-	-	-	-	1	-
3	Даланжаргалан сумын ЗДТГ	1	-	-	-	1	-	-	-
4	Даланжаргалан сумын ОНХС	1	-	-	-	-	-	1	-
5	Иххэт сумын ОНХС	1	-	-	-	-	-	1	-
6	Өргөн сумын ОНХС	1	-	-	-	-	-	1	-
7	Сайхандулаан сумын ОНХС	1	-	-	-	-	-	1	-
8	Улаанбадрах сумын ОНХС	1	-	-	-	-	-	1	-
9	Хатанбулаг сумын ЗДТГ	1	-	-	-	-	-	1	-
10	Хатанбулаг сумын ОНХС	1	-	-	-	-	-	1	-
11	Хөвсгөл сумын ЗДТГ	1	-	-	-	1	-	-	-
12	Эрдэнэ сумын ИТХ	1	-	-	-	1	-	-	-
13	Эрдэнэ сумын ЗДТГ	1	-	-	-	1	-	-	-
14	Сайншанд сумын ОНХС	1	-	-	-	-	-	1	-
15	Замын-Үүд сумын ОНХС	1	-	-	-	-	-	1	-
16	Мандах сумын ЗДТГ	1	-	-	-	-	-	1	-
17	Чандмань Илч ОНӨХХК	1	-	-	-	1	-	-	-
Нийт		17	-	-	-	5	-	12	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
1	Аймгийн ИТХ	1	0.62	-	-	1	0.62	-	-
2	Дэлгэрэх сумын ЗДТГ	1	10.30	-	-	1	10.30	-	-
3	Хөвсгөл сумын ЗДТГ	1	7.56	-	-	-	-	1	7.56
4	Сайншанд сумын ИТХ	1	0.68	-	-	1	0.68	-	-
5	Сайншанд сумын ЗДТГ	1	18.00	-	-	1	18.00	-	-
6	Замын-Үүл сумын ЗДТГ	1	43.41	-	-	1	43.41	-	-
7	Замын-Үүд сумын ЗАА	1	1.65	-	-	-	-	1	1.65
8	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	1	0.48	1	0.48	-	-	-	-
9	Чандмань Илч ОНӨХХК	1	56.97	-	-	1	56.97	-	-
Нийт		9	139.67	1	0.48	6	129.98	2	9.21
Нийт дүн		26	139.67	1	0.48	11	129.98	14	9.21

